



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг, Баянхонгор сум,  
Номгон баг Утас/факс: (976) 7044 2584  
Вэбсайт: bayankhongor@audit.gov.mn

2020.04.20 № 2/404  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН Г  
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, судалгааг хүргүүлэв.

Хавсралт 79 хуудас.

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД  
АУДИТЫН МЕНЕЖЕР *[Signature]* АЦЭЭНЯМ



005030488

A5-ТООТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГТ  
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### **АУДИТЫН КОД: ГАГ-2020/02-ГА**

БАЯНХОНГОР АЙМАГТ ЭРХ ШИЛЖИЖ ИРСЭН  
УЛСЫН ТӨСВИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГТ  
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Баянхонгор хот 2020 он

**Аудитын менежер А.Цээням**

Утас: 70442424 цахим хуудас: [tseenyma@audit.gov.mn](mailto:tseenyma@audit.gov.mn)

**Ахлах аудитор Б.Азбаяр**

Утас: 99061429 цахим хуудас: [azbayarb@audit.gov.mn](mailto:azbayarb@audit.gov.mn)

**Аудитор Б.Цэрэнчимэд**

Утас: 88117644 цахим хуудас: [tserenchimedb@audit.gov.mn](mailto:tserenchimedb@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу

---



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/10

Номгон

Г Тайлан баталгаажуулах тухай Г

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалаар батлагдсан “Эрх шилжүүлэх” тухай тушаалын 5-р хавсралтын 2.4 дэх заалтыг үндэслэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12 дугаар зүйлийн 12.40 дэх заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын орлогчийн 2020 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 02/924 тоот эрх шилжүүлсэн албан бичгийг үндэслэн **ТУШААХ** нь:

Нэг. Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор / Б.Азбаяр/, аудитор /Б.Цэрэнчимэд / нарт үүрэг болгосугай.

Гурав. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Б.Азбаяр/-т даалгасугай.


ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД  
АУДИТЫН МЕНЕЖЕР



Тушаал-2020

2519132

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/10 тоот тушаалын хавсралт.



Аудитын нэр: “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”

6417143544 МЯН.ТӨГ

№	Шийдвэрийн дугаар	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн	Албан шаардлага	Акт	Зөвлөмж
1	88-89	Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд тулгуурлан өгөөгүйгээс 950.0 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон.	950,000.0	950,000.0		
2		Төсөв батлагдах үед магадлалаар ТЭЗҮ, зураг төсвийг баталгаажуулаагүйгээс 8 төсөл арга хэмжээний төсөвт өртөг 2020 оны төсөвт 7556,1 сая төгрөгөөр нэмэгдэж тусгагдсан байна.	7,556,100.0			7,556,100.0
3	180-182	Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа чанарын баталгааны барьцаанд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43.6 .-т заасны дагуу гэрээнд ашиглалтад орсон барилгын чанарын баталгаанд 5% барьцаа авч байршуулна гэж заасан байхад доорх гүйцэтгэгчээс 121,9 сая төгрөгийн барьцааг дутуу байршуулсан	121,900.0		121,900.0	
	183	Техник хяналтын болон нормчлолын сангийн зардлаас 10649.0 мянган төгрөгийг гүйцэтгэгчид илүү шилжүүлсэн	10,649.0		10,649.0	
<b>ДҮН</b>			<b>8,638,649.0</b>	<b>950,000.0</b>	<b>132,549.0</b>	<b>7,556,100.0</b>

## АГУУЛГА

**БҮЛЭГ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байна уу?** 7

**ЭРХ ШИЛЖИЖ ИРСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨВ ХИЙЛГЭХ, ТҮҮНИЙГ МАГАДЛАЛААР БАТАЛГААЖУУЛАХ АЖИЛ ХУУЛЬ БАТЛАГДСАНЫ ДАРАА ХИЙГДЭЖ БАЙГАА ЗӨРЧИЛ ДАВТАГДАЖ БАЙГАА НЬ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БҮРЭН ХАНГАХ БОЛОМЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.** 7

**А.2 Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр, 2019 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, ТЕЗ-ийн санал зэрэгт тулгуурлан зохистой төлөвлөгдсөн байна.** 7

**А.1.1. Баянхонгор аймагт 2019 онд УТХО-аар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 онд нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдээгдэл болон төсвийн хязгаарт нийцэж байна.** 7

**А.1.2. Баянхонгор аймагт УТХО-аар хэрэгжүүлж буй батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний харьяа байгууллагуудын саналыг үндэслэн батлагдсан байна.** 7

**А.2.1. Зарим төсөл арга хэмжээний зураг төсөвт орчны стандартыг хангахуйц, зайлшгүй тусгах шаардлагатай гадна тохижилт, хашааны ажлыг орхигдуулснаар 422,0 сая төгрөгийн төсөв нэмэгдэх, нэмэгдэл ажлын гэрээ байгуулах шаардлага үүссэн байна.** 8

**А.2.2. Барилга байгууламжийн төсөвт өртгийг зохиох норм, дүрэм, программ өнөөгийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байна.** 9

**А.2.3. ТАХ-ний зураг, төсвийг үнийн зохистой хэмжээг баримтлан зохиож магадлалаар баталгаажуулсан уу.** 10

**А.2.4. Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ зураг төслийг хууль батлагдахаас өмнө магадлалаар баталгаажуулаагүй зөрчил давтагдан гарсаар байна.** 11

**А.2.5. Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг гаргуулж магадлалын дүгнэлтэд тусгаж байгаа ч баримт бичгийн хувийг хадгалах, техникийн баримт бичиг бүрдүүлэх асуудлыг онцгой анхаарах шаардлагатай байна.** 12

**А.2.6. УИХ-аар батлагдсан УТХО-ын төсөл арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа, олгох санхүүжилт боломжтой байна.** 12

**А.2.7. Хөрөнгө шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан уу.** 13

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЭРХ ШИЛЖИН ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮД ДҮНД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ САЙЖИРЧ ЗОРИЛТОД ТҮВШИНД ХҮРСЭН БАЙНА.** 13

**БҮЛЭГ 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?** 13

**Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, гүйцэтгэж буй барилга угсралтын ажил дуусах шатандаа орсон, төсөвт өртөгт өөрчлөлт орж төсөв нэмэгдсэн төсөл арга хэмжээнд санхүүжилтийн эрх нээлгэх зорилгоор тендер зарладаг байдал давтагдсаар байна.** 13

**Б.1.1. 2019 онд шинээр эхэлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх ажлыг эхний улиралд багтаан шилжүүлсэн байна.** 13

**Б.1.2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үйл явц нь хуулийн дагуу явагдаж байгаа боловч үнэлгээний хороог байгуулахад хамгийн их хугацааг зарцуулсан байна.** 15



Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу жишиг баримт бичгийг үндэслэн боловсруулсан байна.....	15
Б.1.4. Төсөв нэмэгдэж батлагдсан ТАХ-ний гүйцэтгэгч барилга угсралтын ажлыг дуусгах шатанд гүйцэтгэлтэй байхад санхүүжилтийн эрх нээлгэх зорилгоор худалдан авах ажиллагаа зохион байгуулж байгаа зөрчил давтагдан гарсаар байна.....	16
Б.1.5. ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь тайлагнаж байгаа хэдий ч гүйцэтгэлтэй уялдуулан тодотгол хийж байгаа зөрчил байна.....	17
Б.2 Захиалагчийн гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сайн байгаагаас гэрээнд заасан ажлыг ихэнх гүйцэтгэгч нар хугацаа алдалгүй гүйцэтгэсэн байна.....	18
Б.2.1. Гүйцэтгэгч гэрээнд заасан ажлыг хугацаандаа бүрэн гүйцэтгэсэн байна.....	18
Б.2.2. Захиалагч болон Мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр арилгуулах арга хэмжээг авч ажилласан байна.....	19
Б.2.3. Гүйцэтгэгч төсөл арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	21
Б.3 Гүйцэтгэгчид санхүүжилтийг олгоходоо бодит гүйцэтгэлд тулгуурлан санхүүжилтийг олгоогүй зөрчил жил бүр давтагдан гарч байна.....	22
Б.3.1. ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтын үе шатны хяналт уялдаа холбоо муутайгаас зарим төсөл арга хэмжээг мэргэжлийн хяналтын улсын байцаагч зогсоосон байна.....	22
Б.3.2. ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд тулгуурлан олгоогүй зөрчил давтагдан гарсан байна.....	23
Б.3.3. Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үйл явцад тавих тавих дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжсэнээр гэрээний хугацаанд багтаан барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлсэн байна.....	25
Б.4 Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, шинээр ашиглалтад орсон бүтээн байгуулалтын ажлууд нь үр ашгаа өгч, төрийн үйлчилгээний хүртээмж сайжирсан байна.....	25
Б.4.1. Засгийн газар, ТЕЗ-дын хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилт, үр дүнг 91,6 хувиар биелүүлж ажилласан байна.....	25
Б.4.2. Засгийн газар, ТЕЗ-д ТАХ-ний тухайн жилд батлагдсан санхүүжилтийг гүйцэтгэлд тулгуурлан олгосноос гадна оны эцэст санхүүжих дүнгийн гүйцэтгээгүй ажлын үлдэгдлийг Засгийн газрын 2019 оны 430 тоот тогтоолын дагуу аймгийн ТЕЗ-чид шилжүүлсэн байна.....	26
Б.4.3. 2019 онд ашиглалтад орсон төсөл, арга хэмжээний бүртгэлд тусгах саналыг хүргүүлсэн бөгөөд хөрөнгө оруулалтаар бий болсон барилгыг хүчин чадлаар нь ашиглаж байна.....	27
ДҮГНЭЛТ:	28
ЗӨВЛӨМЖ:	29



## Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
БСШУСС	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ААН	Аж ахуйн нэгж
ЕБС	Ерөнхий боловсрол сургууль
ЗГҮАХХАХТ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт



## Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт № 1	Баянхонгор аймагт баригдаж буй соёлын төвүүдийн төсөвт өртгийг харьцуулсан судалгаа	9
Хүснэгт № 2	Төсөвт өртгийн материалын үнийн судалгаа	10
Хүснэгт № 3	Төсөвт өртөг нэмээдсэн ТАХ-ний судалгаа	11
Хүснэгт № 4	Санхүүжих дүнг хэрэгжих хугацаатай харьцуулсан судалгаа	12
Хүснэгт № 5	Гүйцэтгэгчид олгосон санхүүжилтийн судалгаа	23

## Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт №1	Төсөл арга хэмжээний төлөвлөлтийн судалгаа	
Хавсралт №2	Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны судалгаа	
Хавсралт № 3	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн судалгаа	
Хавсралт № 4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаад дуусаагүй, орхигдсон барилга, байгууламжийн судалгаа	
Хавсралт № 5	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017-2019 онд ашиглалтад орсон барилга байгууламжийн нэгдсэн судалгаа	
Хавсралт № 5-1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж 2019 онд ашиглалтад орсон барилга, байгууламжийн үр нөлөөний судалгаа-Сургууль, цэцэрлэг	
Хавсралт № 5-2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж 2019 онд ашиглалтад орсон барилга, байгууламжийн үр нөлөөний судалгаа-ЭМС	
Хавсралт № 5-3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж 2019 онд ашиглалтад орсон барилга, байгууламжийн үр нөлөөний судалгаа-Авто зам гүүр	
Хавсралт № 5-4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж 2019 онд ашиглалтад орсон барилга, байгууламжийн үр нөлөөний судалгаа-ЦДАШ, дэд станц	
Хавсралт № 6	Орон нутгийн хэрэгцээ, шаардлагын судалгаа	



## Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын төлөвлөгөө батлах тухай" 2019 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан сэдвийн дагуу, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т гүйцэтгэлийн аудит хийв

### Аудитын зорилт

Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн үр ашигт улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх;

### Аудитын хамарсан хүрээ

Аудитад Баянхонгор аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд санхүүжүүлэхээр баталсан 32 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны болон бусад байгууллага, аймгийн Засаг дарга түүний харьяа байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.

### Аудитын хязгаарлалт

Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хувьд аудитыг гүйцэтгэнэ.

### Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 300, 3000-3100/ Монгол улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа болон судалгаа авах, аймгийн Засаг дарга түүний харьяа байгууллагын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, захиалагч, гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэл, хяналт, санхүүжилтийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлж, асуудлын шинжилгээ, арга зүй, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль



- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
- Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”.
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер А.Цээням хянан удирдаж чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Б.Цэрэнчимэд нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2020 оны 03 дугаар сарын 01-ний эхлүүлж, талбарын ажлыг 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл гүйцэтгэж аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежерийн тушаалаар баталгаажуулж, 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр ҮАГ-ын ГАГ-т болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

**Хүндрэл бэрхшээл**

.Байхгүй.



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДЭД ТАЙЛАН

**БҮЛЭГ 1.** Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байна уу?

*ЭРХ ШИЛЖИЖ ИРСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨВ ХИЙЛГЭХ, ТҮҮНИЙГ МАГАДЛАЛААР БАТАЛГААЖУУЛАХ АЖИЛ ХУУЛЬ БАТЛАГДСАНЫ ДАРАА ХИЙГДЭЖ БАЙГАА ЗӨРЧИЛ ДАВТАГДАЖ БАЙГАА НЬ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БҮРЭН ХАНГАХ БОЛОМЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.*

***А.2 Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр, 2019 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, ТЕЗ-ийн санал зэрэгт тулгуурлан зохистой төлөвлөгдсөн байна.***

*А.1.1. Баянхонгор аймагт 2019 онд УТХО-аар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 онд нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарт нийцэж байна.*

1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд Баянхонгор аймагт хэрэгжүүлэхээр улсын төсөвт тусгагдсан буюу эрх шилжиж ирсэн барилга байгууламж, авто зам, гүүр, их засвар, тоног төхөөрөмжийн 32 объектоос Өлзийт, Эрдэнэцогт, Баянговь сумын ЗДТГ-ын барилга, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга нь Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 1.61, 4.145-т тусгагдаж УИХ-ын гишүүдээр дэмжигдэн, Жаргалант сумын Халуун усны барилга нь БХБЯ-ны саналаар орж батлагдсан байна. Бусад объектууд нь Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 2.111, 3.1.10, 3.2.3, 3.2.49, 3.3.5 дахь заалт, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 7.1.1, 7.1.2, 11.1, 11.2, 12.1, 15.5 дахь заалтын хүрээнд нийцүүлж төлөвлөсөн байна. /Судалгааг /

### Аудитын илрүүлэлт

*Өлзийт, Эрдэнэцогт, Баянговь сумын ЗДТГ-ын барилга, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга, Жаргалант сумын Халуун усны барилга нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол Улсын 2019 онд нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй байна.*

*А.1.2. Баянхонгор аймагт УТХО-аар хэрэгжүүлж буй батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний харьяа байгууллагуудын саналыг үндэслэн батлагдсан байна.*

2 УИХ-аар хэлэлцэгдэн 2019 оны улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад багтаж, Баянхонгор аймагт хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээнээс Баянхонгор сумын 2,7,9-р багт баригдах сургуулийн барилга,



Жаргалант сумын халуун усны барилга, Баянхонгор сумын 14 ортой ЭМТөвийн барилга зэрэг нь аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдан УИХ-ын гишүүдээр дэмжигдэн санал хүргэгдсэн бусад төсөл арга хэмжээг аймгийн ТЭЗ-аас явуулсан саналын дагуу улсын төсөвт батлагдсан байна. /Судалгааг хавсаргав/

**А.2 Төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг магадлалаар баталгаажуулах ажил нь хууль батлагдахаас өмнө хийгээгүйгээс төсөвт өртөг нэмэгдэх, холбогдох хууль тогтоомж зөрчигдөх, чанарын зорилтод түвшин хангагдахгүй байх эрсдэл үүсч болзошгүй байна.**

*А.2.1. Зарим төсөл арга хэмжээний зураг төсөвт орчны стандартыг хангахуйц, зайлшгүй тусгах шаардлагатай гадна тохижилт, хашааны ажлыг орхигдуулснаар 422,0 сая төгрөгийн төсөв нэмэгдэх, нэмэгдэл ажлын гэрээ байгуулах шаардлага үүссэн байна.*

1 Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийн дагуу архитектур төлөвлөлтийн даалгаврыг аймгийн ерөнхий архитектор баталж, зураг төсөв гүйцэтгэгчид хүргүүлсэн байх ёстой бөгөөд 2019 онд Баянхонгор аймаг УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд зураг, төсөв зохиогчид зургийн даалгаврыг хүргүүлсэн байна.

Гэвч Барилга хөгжлийн төвийн магадлалын дүгнэлтэд зургийн даалгаврын огноо шийдвэрийн дугаар байгаа боловч тухайн зургийн даалгавар нь барилгын техникийн баримт бичигт үдэгдээгүй, баримт материалын хувийг авч үлдээгүй байна.

### **Аудитын илрүүлэлт**

*Зарим төсөл арга хэмжээний зураг төсөвт орчны стандартыг хангахуйц, зайлшгүй тусгах шаардлагатай гадна тохижилт, хашааны ажлыг орхигдуулснаар 422,0 сая төгрөгийн төсөв нэмэгдэх, нэмэгдэл ажлын гэрээ байгуулах шаардлага үүссэн байна. Тухайлбал:*

- *Богд сумын 240 суудалтай Соёлын төвийн барилгын зургийн даалгаварт гадна цахилгаан, холбоо дохиолол, дэд өртөө, гадна тохижилтын ажил төсөвт суугдаагүй байснаас 223,9 сая төгрөгийн;*
- *Баянхонгор аймгийн 2,7,9 дүгээр багийн 14 ортой эмнэлгийн барилгын зураг төсөвт гадна хашаа, гэрэлтүүлэг, гадна дулааны худаг хийх төсөвт тусгаагүй байснаас 103,1 сая төгрөгийн төгрөгийн;*
- *Баянхонгор аймгийн 280 хүүхэдтэй цэцэрлэгийн барилгын зураг төсөвт гадна холболт болон гадна хашааны ажлыг тусгаагүйгээс 95,0 сая төгрөгийн;*



Зураг, төсвийн ажлыг хүлээн авахдаа орчны стандартын шаардлага хангасан эсэхийг хянаж, хэрэгцээ шаардлага бүрэн хангасан зураг төсвийг хүлээн авч байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

*А.2.2. Барилга байгууламжийн төсөвт өртгийг зохиох норм, дүрэм, программ өнөөгийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байна.*

1 Баянхонгор аймагт хэрэгжиж буй төсөл арга хэмжээний төсөвт өртгийн нэгдсэн товчоог харьцуулан үзэв.

Баянхонгор аймагт баригдаж буй соёлын төвүүдийн төсөвт өртгийг харьцуулсан судалгаа /сая.төг/

Хүснэгт №1

Төсөл арга хэмжээний нэр	Хүрээмарал Соёлын төв	Богд Соёлын төв	Эрдэнэцогт Соёлын төв	Бууцагаан Соёлын төв
Зураг төсөл зохиогчийн нэр	“ЦЭСДА” ЗБН	“ЦЭСДА” ЗБН	“ЦЭСДА” ЗБН	“ОСИБ-ТЗ” ХХК
Ажиллах хүчний зардал	192.7	196.1	95.2	177.8
Материалын зардал	868.8	914.5	670.1	462.5
тээврийн зардал	87.2	84.0	94.4	154.2
машин ашиглалт	71.6	77.7	43.9	33.9
шууд зардлын дүн	<b>1220.3</b>	<b>1272.3</b>	<b>903.6</b>	<b>828.4</b>
нэмэгдэл зардал /74.15%/	72.6	73.8	35.9	65.7
Ашиг /15%/	193.9	145.4	101.9	134.1
Барилга угсралтын ажлын дүн	<b>1486.8</b>	<b>1491.5</b>	<b>1041.4</b>	<b>1028.2</b>
НӨАТ 10%	148.7	149.2	104.1	102.8
Нормчлолын сан /0.18%/	2.7	2.7	1.9	1.8
Дүн	<b>1638.2</b>	<b>1643.4</b>	<b>1147.4</b>	<b>1132.8</b>
Захиалагчийн албаны зардал	29.7	29.8	20.8	20.6
Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	37	29.8	32.9	0
Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	14.9	9.9	8.8	10.3
Дүн	<b>1719.8</b>	<b>1712.9</b>	<b>1209.9</b>	<b>1163.7</b>
Магадлашгүй ажлын зардал	29.7	29.8	20.8	20.6
ДҮН	<b>1749.5</b>	<b>1742.7</b>	<b>1230.7</b>	<b>1184.3</b>
<b>Нийт талбай м2</b>	1669.2	1669.2	1179.7	1095.6
<b>1 м2-ийн үнэ /Мянган төгрөг/</b>	1,048.1	1,044.0	1,043.2	1,081.0

Дээрх харьцуулалтаас харахад, ижил хэмжээтэй барилгын төсөвт тооцогдсон зардлын үзүүлэлтүүд нь ойролцоо байгаагаас харахад төсвийг нэг норм дүрмийн дагуу гүйцэтгэж байна гэж үзэв. Тухайн төсөвт мэргэжлийн байгууллага, экспертээр магадлал хийлгэж байгаа тул эрсдэл бага гэж үзэв.

Баянхонгор аймаг хэрэгжиж буй УТХО-ын төсөл арга хэмжээний ихэнх буюу 13 төсөл арга хэмжээний зураг төвийг гүйцэтгэсэн “ЦЭСДА” ХХК-ийн захирал Ц.Орхонтамираас зураг, төсвийн гүйцэтгэж буй программ, түүний үйл ажиллагааны талаар тодруулахад: “Тус компани нь Барилгын яамны тусгай зөвшөөрлөөр Барилгын зураг төсөл зохиогчдын холбооноос худалдан борлуулдаг, барилгын



зургийн “Autocad-2019”, барилгын эскиз зургийн “3d autocad-2020”, барилгын бүтээцийн тооцооллын “Lira”, төсвийн “Stimator-Pro” зэрэг орчин үеийн программуудаар ТЭЗҮ, зураг төсвийг гүйцэтгэж байна. Барилгын зураг төсөл зохиогчдын холбооны гишүүн байгууллага учир тус холбооноос жил бүр тухайн программ-д орсон шинэчлэл, сайжруулалт болон барилгын материалын норм, нормчлол, үнэ зэргийн өөрчлөлт, шинэчлэлийг бэлтгэн нийлүүлж, байнгын холбоотой ажилладаг” гэсэн тайлбар өглөө.

Иймд барилга байгууламжийн төсөвт өртгийг зохиох норм, дүрэм, программ өнөөгийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байна гэж үзлээ.

*А.2.3. ТАХ-ний зураг, төсвийг үнийн зохистой хэмжээг баримтлан зохиож магадлалаар баталгаажуулсан уу.*

1 Баянхонгор аймагт хэрэгжиж буй төсөл арга хэмжээний төсөвт тусгагдсан зарим материалын үнийн судалгаа хийв.

#### Хүснэгт № 2. Төсөвт өртгийн материалын үнийн судалгаа

№	ТАХ-ний нэр	Зураг төсөв зохиогч	Материалын нэр				Цонх /м2/
			Арматур /тн/	Цемент /тн/	Катанка /тн/	хөнгөн Блок /м3/	
	2019 оны 05-р сарын зах зээлийн үнэ /barilga.mn сайт/		1,760,000	166,980	1,760,000	140,000	108,500.0
1	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	"Урбан вижн" ХХК	1,700,000	200,000	1,650,000	138,000	115,000
2	Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	"ЦЭСДА" ЗДН	1,650,000	200,000	2,100,000	135,000	115,000
3	Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/	"ЦЭСДА" ЗДН	1,760,000	167,000	1,760,000	130,000	102,000
4	Соёлын төвийн барилга, 250 суудал /Баянхонгор, Бууцагаан сум/	"ОСИБ-ЗТ"ХХК	1,600,000	180,000	1,900,000	217,000	175,000
5	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	"ЦЭСДА" ЗДН	1,580,000	165,000	1,800,000	130,000	110,000
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	"ЦЭСДА" ЗДН	1,650,000	165,000	1,660,000	135,000	115,000

Дээрх хүснэгтээс харахад төсөв зохиохдоо тухайн үед мөрдөгдөж байсан зах зээлийн дундаж үнэтэй ойролцоо үнээр тооцсон байгаагаас харахад материалын үнийн судалгааг зэх зээлийн үнэ ханштай уялдуулан тооцсон гэж үзэхээр байна.



А.2.4. Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ зураг төслийг хууль батлагдахаас өмнө магадлалаар баталгаажуулаагүй зөрчил давтагдан гарсаар байна.

1 Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуулийг УИХ-ын 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хурлаар баталсан бөгөөд УТХО-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Баянхонгор аймагт хэрэгжүүлэхээр тусгасан Усан бассейн, спорт цогцолбороос бусад төсөл арга хэмжээ нь төсөв батлах үед ТЭЗҮ, зураг төсвийг магадлалаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 29-р зүйлийн 29.4<sup>1</sup> дэх заалтыг зөрчсөн байна.

### Аудитын илрүүлэлт

Төсөв батлагдах үед магадлалаар ТЭЗҮ, зураг төсвийг баталгаажуулаагүйгээс 8 төсөл арга хэмжээний төсөвт өртөг 2020 оны төсөвт 7556,1 сая төгрөгөөр нэмэгдэж тусгагдсан байна.

#### Хүснэгт № 3 Төсөвт өртөг нэмэгдсэн ТАХ-ний судалгаа

сая төгрөг

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	УИХ-ын 2019 оны УИХ-аар батлагдсан дүн	УИХ-ын 2020 оны УИХ-аар батлагдсан дүн	нэмэгдсэн дүн
1	IV.1.3	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	850.0	1,270.1	420.1
2	XII.1.1.5	Дотуур байрын барилга /Баянхонгор, Жинст сум/	1500.0	2,480.0	980.0
3	XII.1.1.216	Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/	3,432.9	4,383.0	950.1
4	XII.1.1.241	Сургуулийн барилга, 960 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номундалай сургууль/	6,500.0	9,126.2	2,626.2
5	XII.2.1.62	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Галуут сум/	1,230.0	1,970.0	740.0
6	XII.2.1.63	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Заг сум/	1,230.0	1,767.7	537.7
7	XII.2.1.66	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	1,230.0	1,830.0	600.0
8	XII.1.1.210	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Баянбулаг сум/	1,140.0	1,842.0	702.0
НИЙТ ДҮН			17,112.9	24,669.0	7,556.1

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад батлуулах төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг урьдчилан хийлгэж, магадлалаар баталгаажуулсны дараа төсөвт оруулан батлуулж, Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

<sup>1</sup> Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана



Мөн дээрх зөрчлийг зогсоох талаар гүйцэтгэлийн аудитын нэгдсэн тайланд тусгуулах саналыг ҮАГ-ын ГАГ-т хүргүүлэв.

*А.2.5. Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг гаргуулж магадлалын дүгнэлтэд тусгаж байгаа ч баримт бичгийн хувийг хадгалах, техникийн баримт бичиг бүрдүүлэх асуудлыг онцгой анхаарах шаардлагатай байна.*

1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд гүйцэтгэх газрын болон техникийн нөхцөл шаардлагатай 30 төсөл арга хэмжээний дотор УИХ-аар төсөв нь батлагдахаас өмнө 15 төсөл арга хэмжээний газрын зөвшөөрлийг авсан, 8 төсөл арга хэмжээний газрын зөвшөөрөл хууль батлагдсаны дараа авсан, 7 төсөл арга хэмжээний газрын зөвшөөрөл хэзээ, ямар хугацаанд авсан эсэх нь тодорхой бус байна.

Техникийн нөхцөлийн зөвшөөрлийг 13 төсөл арга хэмжээ хууль батлагдахаас өмнө буюу журмын дагуу авсан, 10 төсөл арга хэмжээ хууль батлагдсанаас хойш, 7 төсөл арга хэмжээний техникийн нөхцөлийн зөвшөөрөл авсан эсэх баримт тодорхой бус байна. /Судалгааг хавсаргав/

*А.2.6. УИХ-аар батлагдсан УТХО-ын төсөл арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа, олгох санхүүжилт боломжтой байна.*

1 УИХ-аар батлагдсан УТХО-ын төсөл арга хэмжээний хэрэгжүүлэх хугацааг санхүүжих хувьтай харьцуулан судалгаа хийв.

**Хүснэгт № 4 Санхүүжих дүнг хэрэгжих хугацаатай харьцуулсан судалгаа /сая төг/**

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Санхүүжих хувь	Дундаж хувь	Дунджаас хэлбэлзсэн хувь
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Баянговь сум/	2019	2020	979.5	800.0	81.67	57.04	24.63
2	Сургуулийн барилга, 640 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	2019	2020	5,166.1	4,086.7	79.11	57.04	22.07
3	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Хүрээмарал сум/	2019	2020	1,749.6	400.0	22.86	57.04	(34.18)
4	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Шинэжинст сум/	2019	2020	1,230.0	1,000.0	81.30	57.04	24.26
5	Соёлын төвийн барилга, 250 суудал /Баянхонгор, Бууцагаан сум/	2019	2020	1,900.0	400.0	21.05	57.04	(35.99)
6	Эрүүл мэндийн төвийн их засвар, өргөтгөл /Баянхонгор, Баацагаан сум/	2019	2020	827.3	700.0	84.61	57.04	27.57



Баянхонгор аймагт 2019 онд хэрэгжих ТАХ-нүүдийг санхүүжих дүн нь дунджаар 57 хувь бөгөөд төсөл арга хэмжээг дундаж хувьтай харьцуулахад дээрх 6 төсөл арга хэмжээ нь хамгийн их хэлбэлзэлтэй санхүүжих дүнтэй байна.

Хүснэгтээс харахад санхүүжилт 80 орчим хувь батлагдсан Баянговь сумын ЗДТГ, Шинэжинст сумын соёлын төв, Баацагаан сумын ЭМТ-ийн ажлууд хэрэгжиж дууссанаас харахад санхүүжих дүнг ТАХ бүрээр хэрэгжих боломжтой байдлаар баталсан байна.

Харин Хүрээмарал, Бууцагаан сумдын соёлын төвийн санхүүжилтийн 20 хувийг санхүүжүүлэх дүнгээр батлагдсан нь дараа жилдээ хэрэгжих хугацаандаа амжиж хийгдэхэд эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

*А.2.7. Хөрөнгө шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан уу.*

1 Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн 45 төсөл арга хэмжээний жагсаалтад хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна.

Бүлэг 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЭРХ ШИЛЖИН ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮД ДҮНД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ САЙЖИРЧ ЗОРИЛТОД ТҮВШИНД ХҮРСЭН БАЙНА.

***Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, гүйцэтгэж буй барилга угсралтын ажил дуусах шатандаа орсон, төсөвт өртөгт өөрчлөлт орж төсөв нэмэгдсэн төсөл арга хэмжээнд санхүүжилтийн эрх нээлгэх зорилгоор тендер зарладаг байдал давтагдсаар байна.***

*Б.1.1. 2019 онд шинээр эхэлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх ажлыг эхний улиралд багтаан шилжүүлсэн байна.*

1 Баянхонгор аймагт 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 28 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны тендер зарлах эрх шилжиж ирснээс 27 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 1 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар зохион байгуулжээ.

Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн 388 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар аймаг, нийслэлд худалдан авах ажиллагааг зохион байгуулах жагсаалтыг баталсан бөгөөд тухайн жагсаалтад Баянхонгор аймагт 24 төсөл арга хэмжээг зохион байгуулахаар батлагдаж, 4 төсөл арга хэмжээн ТЕЗ-аас эрх шилжүүлсэн байна.



Тогтоолын дагуу БСШУС-ын сайд 2019 оны 02-р сарын 14-ний өдрийн А/69 тушаалаар, Эрүүл мэндийн сайд 2019 оны 01-р сарын 29-ний өдрийн А/43 тоот албан бичгээр, БХБ-ын сайд 2019 оны 02-р сарын 27-ны өдрийн № 39 тоот албан бичгээр, ЗТХ-ийн сайд 2019 оны 01-р сарын 10-ны өдрийн 08 дугаар тушаалаар тус тус ТАХ-ний эрхийг шилжүүлсэн байгаагаас үзэхэд Засгийн газрын 388 тоот тогтоолоор шийдвэрлэсэн хугацаанаас 14-60 хоногийн дараа шийдвэрлэсэн байна.

Харин тогтоолд тусаагүй ХЗДХС-ын 2018 оны 12-р сарын 21-ний өдрийн А/236 тоот албан бичгээр VIII.2.1.8 хуулийн дугаартай Цагдаагийн газрын бэлтгэлийн төвийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/, ЗГХЭГ-ын даргын 2019 оны 05 тоот тушаалын 2 хавсралтаар IV.1.3 хуулийн дугаартай Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Эрдэнэцогт сум/, ХЗДХС-ын 2019.06.03-ны А/98 тоот албан бичгээр VIII.6.1.1 хуулийн дугаартай Архивын хэлтсийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/, ЭМС-ийн 2019.02.04-ний өдрийн А/63 тоот албан бичгээр XVII.2.2.7 хуулийн дугаартай Бөмбөгөр сумын ЭМТ-ийн барилгын халаалтын засварын ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг тус тус шилжүүлсэн байна.

### Аудитын илрүүлэлт

*Тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш БСШУСС 2019.02.14-нд буюу 102 хоногийн дараа, БХБС 2019.02.27-нд буюу 115 хоногийн дараа, ЗТХС 2019.01.10-нд буюу 68 хоногийн дараа эрх шилжүүлсэн нь Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалын 1-р хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнах журам”-ын 2.11<sup>2</sup>-дахь заалттай нийцэхгүй байна.*

*Мөн аймгийн Засаг дарга эрх шилжиж ирснээс хойш Баянбулаг сумын сургууль, Галуут сумын соёлын төвийн барилгад тус бүр 29 хоног, Заг сумын соёлын төвийн барилгад 76 хоногийн дараа үнэлгээний хороог байгуулсан нь цэвдэг бүхий хөрстэй дээрх ТАХ-үүдийн хувьд технологийн горимын дагуу газар хөлдөх хүртэлх хугацаанд ажил эхлэхгүй хүлээгдэх, тайлант онд бүрэн хэрэгжих боломж алдагдах нөхцөл байдал үүсэж байна.*

Иймд цаашид Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалын 1-р хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнах журам”-ын 2.11 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг холбогдох яамдад хүргүүлэх, эрх шилжсэн дээрх онцлог бүхий

<sup>2</sup> Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх



ТАХ-ний худалдан авах ажиллагааг шийдвэр ирсэн дариуд нь хугацаа алдахгүй зохион байгуулж, бүрэн хэрэгжих боломжоор хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

*Б.1.2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үйл явц нь хуулийн дагуу явагдаж байгаа боловч үнэлгээний хороог байгуулахад хамгийн их хугацааг зарцуулсан байна.*

1 Улсын төсвөөр хэрэгжих 28 төсөл, арга хэмжээнээс 3 ТАХ-ний эрхийг 2018 оны 12-р сард, 7 төсөл, арга хэмжээний эрхийг 2019 оны 1 дүгээр сард, 17 ТАХ-ний эрхийг 2019 оны 2-р сард 1 төсөл арга хэмжээний эрхийг 2019 оны 06-р сард шилжүүлсэн байхад үнэлгээний хороог дунджаар 46 хоногийн дараа байгуулсан байна. Үүнээс хамгийн богино хугацаанд үнэлгээний хороог байгуулсан 8 хоног буюу Жаргалант сумд байршилтай Халуун усны байрын барилга, хамгийн урт хугацаанд буюу 110 хоногт Бууцагаан сумын Соёлын төвийн барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулжээ.

Архивын хэлтсийн барилгын эрх шилжүүлэх шийдвэр 2019.06.03-ний өдөр гарсан байхад аймгийн Засаг дарга 2019.05.22-ний өдөр урьдчилан үнэлгээний хороог байгуулжээ.

Үнэлгээний хороо нь байгуулагдсанаас хойш дунджаар 8 хоногт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан бөгөөд хамгийн богино хугацаанд буюу үнэлгээний хороо байгуулагдсан тухай өдөр нь Баянговь сумын ЗДТГ-ын барилгын гүйцэтгэгчийг, хамгийн ихдээ 54 хоногт Эрдэнэцогт сумын ЗДТГ-ын барилгын тендерийг зарласан байна.

Нээлттэй тендерийг зарласнаас хойш тендерийг нээх, гэрээ байгуулах хугацаа нь хууль журамд заасан хугацааг мөрдөж ажилласан бөгөөд, үнэлгээний хороо байгуулсан тохиолдолд худалдан авах ажиллагаанд хугацаа алдаагүй байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад үнэлгээний хороог байгуулахад хамгийн их хугацаа зарцуулжээ.

*Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу жишиг баримт бичгийг үндэслэн боловсруулсан байна.*

1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг боловсруулан дунджаар 8 хоногийн дараа тендерийг зарласан байна.



Тендерийн баримт бичгийг тендерийн жишиг баримт бичгийг үндэслэн дунджаар 11-15 ерөнхий шаардлагыг тавьж боловсруулсан бөгөөд оновчтой шаардлага тавьж ажилласны үр дүнд төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид ажлаа гэрээнд заасан хугацаандаа биелүүлж байна.

*Б.1.4. Төсөв нэмэгдэж батлагдсан ТАХ-ний гүйцэтгэгч барилга угсралтын ажлыг дуусгах шатанд гүйцэтгэлтэй байхад санхүүжилтийн эрх нээлгэх зорилгоор худалдан авах ажиллагаа зохион байгуулж байгаа зөрчил давтагдан гарсаар байна.*

1 Тендер шалгаруулалтын холбоотой мэдээлэл, тендерт оролцоход шаардлагатай бүрдүүлэх материал, урилгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй мэдээлж, Тендер шалгаруулалтыг зарлахдаа тендерийн урилга, холбогдох баримтыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим сайтаар болон “Монголын үнэн” сонин хэвлэлээр олон нийтэд нээлттэй мэдээлж, оролцох байгууллагын цахимаар авч, тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулан, оролцогч болон үнэлгээний хорооны гишүүдийг байлцуулан тодорхой, товлосон цагт нээж байгаа нь гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган Сангийн сайдын 2013 оны 84-р тушаалаар батлагдсан “Цахим сүлжээнд тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

Эрдэнэцогт сумын ЗДТГ-ын барилга угсралтын ажилд ашиглагчийн зүгээс хүсэлт гарган зоорин давхар болон цэвэр ус, ариутгах татуургын холболтын ажлыг нэмж хийхээр санал гаргаж 420,1 сая төгрөгийн нэмэлт зураг төсвийг зохиогчоор хийлгүүлэн зураг төсөвт өөрчлөлт оруулсан ба 2019 оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад 420,1 сая төгрөгийн нэмж батлагдсан байна.

Он дамжин хэрэгжиж буй дээрх төсөл, арга хэмжээний төсөв нэмэгдсэн, нэмэгдсэн төсөв нь нийт төсөвт өртгийн 15 хувиас хэтэрсэн тул ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу дахин тендер зарлаж байгаа боловч тухайн барилгын гүйцэтгэл нь дууссан байсан бөгөөд тухайн тендерт өмнөх гүйцэтгэгчийг оролцуулан сонгон шалгаруулахаас өөр боломжгүй тендер зохион байгуулж байгаа нь бодит байдалтай нийцэхгүй, зөвхөн Төсвийн тухай хуульд заасны дагуу санхүүжилт авах зорилгоор худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүний шалтгаан нь төсөв батлагдах үед зураг төсөвт магадлал хийгдээгүй, хэрэгцээ шаардлагыг бодитой тодорхойлоогүйгээс шалтгаалж байгаа бөгөөд цаашид ч тухайн зөрчил давтагдан гарахаар байна.



Иймд төсөвт өртөг нь батлагдаж магадлалаар орсон ТАХ-г хөрөнгө оруулалтын жагсаалтад батлах шаардлагатай байна.

*Б.1.5. ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь тайлагнаж байгаа хэдий ч гүйцэтгэлтэй уялдуулан тодотгол хийж байгаа зөрчил байна.*

1 Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тайланг Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, журам”-ын дагуу батлагдсан маягтаар болон бичмэл тайлангаар хагас бүтэн жилээр гарган Сангийн яаманд хүргүүлж ажилласан байна.

### Аудитын илрүүлэлт

*Аймгийн засаг даргын 2018 оны 12 сарын 5-ны өдрийн А/804 дүгээр захирамжаар “Улсын болон орон нутгийн төсөв бусад сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө батлах тухай” баталсан боловч төлөвлөгөөнд заасан хугацааг гүйцэтгэлтэй уялдуулан удаа дараа тодотгосон байна.*

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухай жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан өөрчлөлтийг тусгана гэж заасан байхад шалтгаангүйгээр гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалын 1-р хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнах журам”-ын 2.6<sup>3</sup>-дахь заалттай нийцэхгүй байна.

Иймд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалын 1-р хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнах журам”-д заасны дагуу бодитой төлөвлөж, журамд заасны дагуу дотоод хяналтын нэгжээр хянуулан ТЕЗ-аар батлуулан өөрчлөлт орсон тохиолдолд “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх

<sup>3</sup> ТЕЗ болон төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд нь тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусгах төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.



тайлагнах журам”-ын 2.9<sup>4</sup> дэх заалтын дагуу тайлагнахдаа тодорхой тусгаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

***Б.2 Захиалагчийн гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сайн байгаагаас гэрээнд заасан ажлыг ихэнх гүйцэтгэгч нар хугацаа алдалгүй гүйцэтгэсэн байна.***

***Б.2.1. Гүйцэтгэгч гэрээнд заасан ажлыг хугацаандаа бүрэн гүйцэтгэсэн байна.***

1 Баянхонгор аймагт 2019 онд эрх шилжин ирсэн 32 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 19 нь бүрэн хэрэгжсэн ба 3 төсөл арга хэмжээ нь өмнө онд дууссан тухайн онд үлдэгдэл санхүүжилт олгогдохоор батлагдсан, үлдсэн 16 төсөл арга хэмжээний 1 нь засварын ажил 15 нь барилга угсралтын ажил байгаагаас 5 нь өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа, 10 нь тухайн онд гэрээ байгуулж шинээр эхэлсэн төсөл арга хэмжээнүүд байна.

Хэрэгжиж дууссан 19 төсөл, арга хэмжээнээс 17 төсөл арга хэмжээнд улсын комиссын актаар баталгаажсан бөгөөд Эрдэнэцогт болон Шинэжинст сумын соёлын төвийн комиссын акт нь албажих шатандаа байна.

Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын 32 төсөл арга хэмжээнээс 13 нь дараа онд шилжиж байгаагийн 12 төсөл арга хэмжээ нь хуулийн дагуу 2020-2021 онд дуусахаар байна. Харин Жинст сумд баригдаж байгаа 240 суудалтай соёлын төвийн хуульд заасан хугацаа нь 2019 оноор дуусгавар болж байгаа тул хяналтыг сайжруулан гэрээний үүргийн биелэлтийг хангуулж, гэрээнд заасны дагуу алданги тооцож хариуцлагын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөв.

Аудитаар ашиглалтад орсон ТАХ-ний чанар байдлыг газар дээр нь очиж үзэхэд зарим төсөл арга хэмжээ нь ашиглалтын явцад чанарын шаардлага хангахгүй байна. Тухайлбал:

### **Аудитын илрүүлэлт**

- 1. Баян-Овоо сумын сургуулийн халаалтын радиаторын тагаар ус тусч, зарим хэсгээр булан, холбоосыг муу гагнаснаар шалны доогуур ус гоожсон байдалтай.*
- 2. Жаргалант сумын халуун усны барилгын агааржуулалтын хоолойгоор шороо нурж орж ирдэг.*

<sup>4</sup> Захиалагч тухайн жилд батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мөрдөж ажиллах бөгөөд төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагааны талаарх тайлбар үндэслэлийг худалдан авах ажиллагааны тайланд тодорхой тусгана.



Иймд дээрх зөрчлийг Барилгын тухай хуульд заасан чанарын баталгааг үндэслэн зөрчлийг арилгуулах албан шаардлагыг зөвлөмжийг хяналт хэрэгжүүлсэн аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

### **Аудитын илрүүлэлт**

Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа чанарын баталгааны барьцаанд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43.6 .-т заасны дагуу гэрээнд ашиглалтад орсон барилгын чанарын баталгаанд 5% барьцаа авч байршуулна гэж заасан байхад доорх гүйцэтгэгчээс 121,9 сая төгрөгийн барьцааг дутуу байршуулсан байна. Үүнд:

1. Баянхонгор сумд баригдсан 280 ортой цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгч "Гал хонгор" ХХК-аас 99.0 сая төгрөгийн барьцаа байршуулаагүй
2. Баянхонгор сумын 14 ортой эмнэлгийн гүйцэтгэгч "Хан халдун" ХХК-аас 1,8 сая төгрөгийн барьцаа дутуу байршуулсан
3. Эрдэнэцогт сумын ЗДТГ-ын барилгын гүйцэтгэгч "Зүүн шанд" ХХК-аас 21,0 сая төгрөгийн барьцаа байршуулаагүй

Иймд гэрээнд заасны дагуу дээрх 121,9 сая төгрөгийн барьцааг орон нутгийн хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулах төлбөрийн акт тогтоов.

*Б.2.2. Захиалагч болон Мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр арилгуулах арга хэмжээг авч ажилласан байна.*

1 Баянхонгор аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар эрх шилжсэн болон эрх шилжээгүй 92,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд аймгийн ГХБХБГ нь Барилгын хөгжлийн төвтэй байгуулсан гэрээний дагуу 29 барилга байгууламжид хамтран захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд нэг барилга дээр давхардсан тоогоор 6 удаа хяналт хийж гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд хяналт хийж илэрсэн зөрчлийг барилга байгууламжийн хяналтын дэвтэрт тухай бүрд нь тусгаж зөрчлийг арилгуулдаг бөгөөд явцын хяналтаар илэрсэн зөрчилд өгсөн үүрэг даалгавраас дурдвал:

- **Баянхонгор сумын 2,7,9-р багт баригдаж байгаа 640 хүүхдийн сургууль**
  - Спорт заалны баганын 16,10 арматурын зураг төслийн дагуу зангидаж хог хаягдал орохооргүй сайтар битүүлж орхин, цутгалтын ажлыг дулааны улиралд хийж гүйцэтгэх.
  - Парпетны цутгалтыг хийхдээ хүйтний нэмэлт хийж цутгаж дулаалах.
  - Блокын өрлөг хийхдээ 2 үе тутамд анкер бэхлэлгээ хийж, шаварт давс хийх.
  - Цонх суух хэсэгт тоосгон өрлөг өрөх
- **Жинст сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл**
  - Бетонон хийцэд үл эвдэх аргаар шинжилгээ хийлгэж чанарыг тодорхойлуулах.



- Дүүргэлтийн блокыг шинжилгээнд өгөх. /Шинжилгээг ГХБХБГ шинжлүүлж, чанарын шаардлага хангасан гэсэн дүгнэлт гарсан/

• **Жинст сумын 240 хүүхдийн сургуулийн барилга**

- 3-р давхрын өрлөгийн ажлыг хийхдээ хүйтний нэмэлттэй хийх.
- Хамар ханын өрлөгийн материалыг шинжилгээнд хамруулах.
- Гадна пасад болон нойтны ажлыг дулааны улиралд хийж гүйцэтгэх

Барилгын ажлыг зогсоохдоо технологийн горим баримталж хамгаалалт дулаалгыг хийж зогсоох

• **Жинст сумын 240 хүний соёлын төв**

- Заалны карказын тэнхлэгийн хэв гажилтыг мэргэжлийн байгууллагаар үзүүлж шалгуулах. Шаардлагатай тохиолдолд нэмэлт хүчитгэл хийлгэх.
- Заалны суурийг дагуулж босоо өрсөн тоосгон өрлөгийг хүчитгэх.
- Бетоны үл эвдэх шинжилгээ хийлгэх. Мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсны дараа барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх.

Захиалагч нь барилга угсралтын ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласны үр дүнд зөрчлүүдийг тухай бүрд нь засаж, залруулж байгаа нь цаашид барилгын чанар, насжилт сайжрах нөхцөлийг хангуулж байна.

Зохиогчийн хяналтыг захиалагчтай хийсэн гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжилт дуусаж хүлээн авсан барилгын хувьд зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт гаргаж захиалагчид ирүүлдэг бөгөөд, хэрэгжиж дуусаагүй барилгын хувьд хяналтын тайланг явцын дундуур захиалагчид ирүүлээгүй байна.

Зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлтэд барилга явцад илэрсэн зөрчлийг тухай бүрд засаж, залруулж байсныг тусгасан байна. Тухайлбал: Өлзийт сумын сургуулийн барилгын бетон цутгах ажлыг гүйцэтгэхээс өмнө бетоны орц нормыг яаралтай тодорхойлуулах үүрэг даалгавар өгч, тодорхойлуулсан байна.

Харин ашиглалтад ороогүй байгаа Жинст сумын ЭМТ, Жинст сумын Соёлын төвийн барилгын ажилд хийсэн зохиогчийн хяналтын тайланг ирүүлээгүй бөгөөд эдгээр барилгын гүйцэтгэлийн явцад аймгийн МХГ-аас 2019 оны 10-р сард хяналт хийж, Барилгын тухай хууль, холбогдох дүрэм, журам, норм, норматив, стандартыг зөрчсөн байх тул тус барилгуудын барилга угсралтын ажлыг түр зогсоож, зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн байна. Үүнд:

**1. Жинст сумын Эрүүл мэндийн төв**

- Барилгын багануудын тэнхлэг хоорондын зай зургаас 1-2 см-ийн алдаатай, шилжилттэй, хэв хашмалын геометр хэмжээ алдсанаас бетон цүлхийсэн.
- Бетоны найрлагад орсон элс, хайргыг угааж, шигшиж ангилж, холбогдох стандартын дагуу зуураагүйгээс хайрга, элс нь бөөгнөрч бетоны бат бэх байдлын тогтворт байдал алдагдсан
- Өргийн хэвтээ, босоо заадас 2-3 см зуурмагт налархайжуулагч хэрэглээгүй



- Баганаас өргийн гаргалгаа арматур гараагүй
- Барилгын хоёрдугаар давхрын хучилтын бетоны нягтруулалт хангалтгүй, элс хайрга холигдоогүй, бат бэх төслийн шаардлагад нийцэхгүй

## 2. Жинст сумын соёлын төв

- Үзэгчдийн заалны багануудын тэнхлэг хоорондын зай зургаас 4-6 см-ийн алдаатай, шилжилттэй, хэв хашмалын геометр хэмжээ алдсанаас бетон цүлхийсэн, овон товон ан цав үүссэн.
- Бетоны найрлагад орсон элс, хайргыг угааж, шигшиж ангилж, холбогдох стандартын дагуу зуураагүйгээс хайрга, элс нь бөөгнөрч бетоны бат бэх байдлын тогтворт байдал алдагдсан
- Өргийн хэвтээ, босоо заадас 2-3 см зуурмагт налархайжуулагч хэрэглээгүй
- Өргийн уулзварын торлолт хангалтгүй
- Баганаас өргийн гаргалгаа арматур гараагүй
- Барилгын үзэгчдийн заалны түшэц ханыг эвдэж, хаалга гаргасан нь бат бэх, тогтворт аюулгүй байдлыг алдагдуулсан, нягтруулалт хангалтгүй

